



ТАНИЛЦУУЛГА

Үндэсний баялгийн сангийн
2024 оны төсвийн тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургаадугаар зүйлийн 2 дахь хэсэгт оруулсан 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр баталгаажуулсан байгалийн баялаг, түүний дотор газрын хэвлийн баялгийг ашиглах суурь зарчим, нөхөн сэргээгдэхгүй эрдэс баялгаас бий болсон үр өгөөжийг өнөө ба хойч үеийн иргэн бүрд тэнцвэртэй хуваарилах үзэл санааг хэрэгжүүлэх зорилготой Үндэсний баялгийн сангийн тухай хууль 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр батлагдан, хүчин төгөлдөр хэрэгжиж эхлээд байна.

Сүүлийн 30 орчим жилийн хугацааны үзүүлэлтээс үзвэл Монгол Улсын нийгэм, эдийн засаг нь байгалийн баялаг, түүний дотор газрын хэвлийн баялаг, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын нөөц ашигласны үр өгөөжөөс ихээхэн хамааралтай болох нь харагддаг. Тодруулбал, эрдэс баялгийн салбарын орлого нь 2020 онд Монгол Улсын нэгдсэн төсвийн 25.7 хувийг¹, 2021 онд 28.9 хувийг², 2022 онд 35.1 хувийг, 2023 онд 33.3 хувийг бүрдүүлж байв.

Эрдэс баялгийн салбараас төсөвт төвлөрөх орлогыг одоо ба ирээдүйн иргэдэд тэгш хүртээх, хуваарилах зорилгоор Монгол Улсын Их Хурлаас өмнө нь тухайлсан нэг сантай холбогдох харилцааг зохицуулах зорилготой хууль тогтоомж буюу Монгол Улсыг хөгжүүлэх сангийн тухай хууль, Хүний хөгжил сангийн тухай хууль, Ирээдүйн өв сангийн тухай хуулийг тус тус баталж байсан бол энэ оны 04 дүгээр сарын 19-ний өдөр Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг баталж, Ирээдүйн өв сан, Хуримтлалын сан, Хөгжлийн сан гэсэн гурван төрөлжсөн сангаас бүрдэх тогтолцоог бий болгоод байна.

Ингэснээр Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сан бүрд 2024 оны төсвийн жилд эх үүсвэр төвлөрүүлэх, хуримтлал үүсгэх болон эдгээртэй холбоотой харилцааг нарийвчлан зохицуулах зорилгоор Үндэсний баялгийн сагийн 2024 оны төсвийг боловсруулж, батлах эрх зүйн орчин бүрдээд байна.

Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл батлагдсанаар Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сан бүрд 2024 оны төсвийн жилд орлого төвлөрүүлж, хуримтлуулан Үндэсний баялгийн сангаар дамжуулан байгалийн баялгийг хуваарилах, өгөөж хүртэх Үндсэн хуулийн суурь зарчим хангагдана.

Хуулийн төслийн зүйл тус бүрээр:



¹Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Эрдэс баялгийн салбарын статистик мэдээлэл (2020 - I-XII), 1 дэх тал.

²Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Эрдэс баялгийн салбарын статистик мэдээлэл (2021, I-XII), 2 дахь тал.

Хуулийн төсөл 2 бүлэгтэй байх бөгөөд доор дурдсан агуулгатай байна.
Үүнд:

Нэгдүгээр бүлэгт хуулийн нийтлэг үндэслэл, зорилт, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн хууль тогтоомжийн талаар;

1 ДҮГЭЭР ЗҮЙЛ –Хуулийн зорилтыг тусгана.

2 ДУГААР ЗҮЙЛ – Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн хууль тогтоомжийн талаар

Хоёрдугаар бүлэгт Үндэсний баялгийн санд 2024 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчийн төвлөрүүлэх орлогын хэмжээ болон хуулийг дагаж мөрдөх хугацааг тус тус тусгана.

3 ДУГААР ЗҮЙЛ – Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сан бүрд төвлөрүүлэх орлогын хэмжээг тусгасан.

4 ДҮГЭЭР ЗҮЙЛ – Ирээдүйн өв сангийн хуримтлалын үлдэгдэл болон 2024 онд нэмж хуримтлуулах хөрөнгийн хэмжээг тусгасан.

5 ДУГААР ЗҮЙЛ – Хуримтлалын сангийн хөрөнгийн удирдлагын хүрээнд хөрөнгө оруулалт хийх хэмжээг тусгасан.

6 ДУГААР ЗҮЙЛ – Хуулийн дагаж мөрдөх хугацааг тусгасан.